



БАНКНЫ САЛБАРЫН ТОЙМ

2022 оны эхний хагас жилийн тайлан

СЭРГЭЛТ ҮҮ?

Нүүдэлчний намар

Банкны салбарын үзүүлэлт харьцангуй тогтвортой, өсөлттэй байлаа. Банкны салбарын нийт актив өмнөх оны мөн үетэй харьцуулахад 3 хувиар нэмэгдлээ. Чанаргүй зээл буурах төлөвтэй байна. Гадаад орчны тодорхой бус байдлаас шалтгаалан иргэдийн дунд валют нөөцлөх, валют хадгалах сонирхол өндөр байгаа нь төгрөгийн хадгаламж буурахад нөлөөлжээ.

Орос-Украины асуудал болон цар тахлын нөхцөл байдлаас шалтгаалсан нийлүүлэлт, ложистикийн хүндрэл нь манай улсын гол нэрийн бараа бүтээгдэхүүний үнэд нөлөөлж, инфляцын түвшин өндөр хэвээр хадгалагдах гол шалтгаан болж байна.

Мөн тээвэр ложистикийн хүндрэлээс үүдэлтэй уул уурхай, барилга болон тээврийн салбарын сэргэлт удаашралтай байгаа нь эдийн засгийн өсөлтөд сөргөөр нөлөөлж буй хэдий ч үйлчилгээ, худалдааны салбарын сэргэлт харьцангуй хурдан байсан нь эдийн засаг 1.9 хувиар өсөхөд чухал нөлөө үзүүлээ.

Цар тахлын үед эдийн засгийн салбаруудыг ганц дэмжиж ирсэн банкны салбарын зээлийн өсөлт үргэлжилсээр байна. Тээвэр ложистикийн хүндрэлийг хурдацтай шийдвэрлэн уул уурхай, барилга болон тээврийн салбарын сэргэлтийг аль болох хурдлуулахгүй бол эдийн засаг тогтвортой өсөх боломжгүй нь харагдаж байна.


Эдийн засгийн үзүүлэлтүүд намрын их бэлтгэл ажилдаа дариу ханцуй шамлан орох шаардлагатай болсныг харуулж байна.



Иргэд цалин, тэтгэвэр болон хадгаламж барьцаалсан зээл ихээр авч байна.


Банкууд иргэдэд хэрэглээний зээлийг түлхүү олгожээ. Худалдааны салбараас бусад салбарт зээл олголт буурчээ.

Онцлох өөрчлөлт,
энгийн тайлбар



Онолын
тодорхойлолт

Бизнесийн зээл олголт, жил бүрийн II улирал



2022 оны 2-р
улирлын
гүйцэтгэл

Банкны шинээр олгосон зээл

Жич: Тухайн жилд банкны шинээр гаргасан зээлийн хэмжээгээр зээлийн үлдэгдэл нэмэгддэг.

Шинээр иргэдэд олгосон
зээлийн хэмжээ нэмэгдэв.

72%

2022 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛД БАНКНЫ САЛБАРЫН ОНЦЛОХ ӨӨРЧЛӨЛТ, ЦААШДЫН ХАНДЛАГА



Банкуудын иргэдэд олгосон зээлийн хэмжээ нэмэгдэв. Худалдааны салбараас бусад салбарт зээл олголт буурчээ.



Банкуудын чанаргүй зээл аажмаар буурах хандлагатай байна.



Тээвэр ложистикийн хэвийн бус үйл ажиллагаанаас үүдэлтэй уул уурхай, барилгын салбарын өсөлт удаашралтай байна.



Системийн нөлөө бүхий 5 банкны санхүүгийн үзүүлэлт харьцангуй сайн байна.



Системийн нөлөө бүхий банкууд ирэх онд багтаан IPO хийнэ.



Цар тахлын болон геополитикийн нөхцөл байдлаас үүдэлтэй тодорхой бус байдал нь импортын гол нэрийн бараа бүтээгдэхүүний үнийг нэмэгдэх суурь шалтгаан болж байна.

БАНКУУДЫН САНХҮҮГИЙН ГОЛЛОХ ҮЗҮҮЛЭЛТ

2022 оны эхний хагас жилийн гүйцэтгэл

Эдийн засгийг дэмжих гол хөдөлгүүр нь банкны зээл хэвээр байна.

Хөтөлбөрийн зээлээр өдөөгдсөн зээлийн өсөлт өндөр хэвээр байна.


Банкны зээлийн багц

Жич: Зээлийн үлдэгдэл нь шинээр олгосон зээлээр нэмэгдэж, эргэн төлөлтөөр буурч байдаг.

+23%

Зээлийн үлдэгдэл 2 дахин өсөв.

Эх сурвалж: Монголбанк
Үндэсний статистикийн хороо




Иргэд цалин, тэтгэвэр болон хадгаламж барьцаалсан зээл ихээр авч байна.

Банкууд иргэдэд хэрэглээний зээлийг түлхүү олгосон байна. Худалдааны салбараас бусад салбарт зээл олголт буурчээ.

Иргэдийн зээл олголт, жил бүрийн II улирал

Тэрбум ₮



Бизнесийн зээл олголт, жил бүрийн II улирал



Банкны шинээр олгосон зээл

Жич: Тухайн жилд банкны шинээр гаргасан зээлийн хэмжээгээр зээлийн үлдэгдэл нэмэгддэг.

Иргэдэд олгосон зээл

72%

НЭМЭГДЭВ.

Банкны зээлийн чанар

Жич: 90 хоногоос дээш хугацаагаар зээлээ төлөөгүй нөхцөлд чанаргүй зээлд шилждэг.

Салбарын хэмжээнд 10 зээл тутмын 1 нь чанаргүй байна.

10%


Эх сурвалж: Монголбанк
Үндэсний статистикийн хороо

Зээлийн багцын чанар аажмаар сайжирч байна.


Хөл хорионы хязгаарлалт үгүй болж иргэд хэвийн амьдралд аажмаар шилжин дотоод эрэлт нэмэгдэх болсноор иргэдийн зээлийн чанаргүйдэл буурч, цар тахлын өмнөх үетэй тэнцэж ирлээ.

Тээвэр, ложистикийн хүндрэлээс үүдэлтэй уул уурхайн салбар эхний улиралд удаашралтай байсан нь тус салбарын 10 зээл тутмын 3 нь чанаргүй болоход нөлөөлжээ.

Иргэдийн чанаргүй зээлийн харьцаа, жилийн бүрийн II улирал



Бизнесийн чанаргүй зээлийн харьцаа, жил бүрийн II улирал




Гадаад орчны тодорхой бус байдлаас шалтгаалан иргэдийн дунд валют нөөцлөх, валют хадгалах сонирхол өндөр байна.

Гадаад орчны тодорхой бус байдлаас үүдэлтэй валют хадгалах, нөөцлөх сонирхол иргэдэд их байна. Төгрөгийн хадгаламжийн бодит өгөөж инфляцаас шалтгаалан буурсан нь иргэдийн төгрөгийн хадгаламжийг буурахад нөлөөлөө.

Банкны эх үүсвэр, жилийн бүрийн II улирал.

Их наяд ₮



Банкны эх үүсвэр

Жич: Энэ нь банкны татан төвлөрүүлсэн харилцах, хадгаламжийг хэлдэг.

Валютын харилцах

30%

НЭМЭГДЖЭЭ.

Банкны жигнэсэн дундаж хүү

Жич: Банкуудын шинээр татсан эх үүсвэрийн хүү, олгосон зээлийн хүү нь цаг хугацаа, мөнгөн дүнгийн хувьд жинлэгдсэн дундаж хүүг хэлнэ.

Зээлийн хүү


14.6%

Эх сурвалж: Монголбанк

Зээлийн хүү тогтвортой байна.

Хадгаламжийн хүү аажмаар нэмэгдэх төлөвтэй байна.

Төв банкнаас гадаад, дотоод эдийн засгийн нөхцөлд үүсэж буй тодорхой бус байдлаас шалтгаалан бодлогын хүүгээ нэмэгдүүлсэн нь зээлийн хүү аажмаар нэмэгдэх хүлээлтийг бий болгож байна.



БАНКУУДЫН САНХҮҮГИЙН ГОЛЛОХ ҮЗҮҮЛЭЛТ

2022 оны эхний хагас жилийн гүйцэтгэл

Банкны актив буюу хөрөнгө

Жич: Банкны нийт өр төлбөр дээр нэмэх нь эздийн өмчийг бүхэлд банкны хөрөнгө буюу актив гэнэ.

Системийн нөлөө бүхий
банкуудын актив


3%

ӨСӨВ.

Банкны системийн нийт актив өмнөх оны мөн үеэс 1.3 их наяд төгрөгөөр нэмэгдсэн байна.

Голомт банкны актив 10 хувиар, ХХБ-ны актив 9 хувиар өсжээ. Харин Хаан банкны актив 0.2 хувиар буурсан байна.


Банкуудын актив, жил бүрийн II улирлаар харуулав.



Банкны салбарын нийт эх үүсвэр өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1 их наяд төгрөгөөр буурчээ.

Хаан банкны эх үүсвэр 0.9 их наяд төгрөгөөр, Төрийн банкны эх үүсвэр 0.2 их наяд төгрөгөөр буурчээ.
ХХБ, Голомт банкны эх үүсвэр өмнөх оны мөн үетэй харьцуулахад нэмэгджээ.

Банкуудын эх үүсвэр, жил бүрийн II улирал



Банкны эх үүсвэр

Жич: Иргэд, байгууллага болон хөрөнгө оруулагчдаас
татсан өр төлбөрийн хэмжээ.

Банкуудын эх үүсвэр

-4%

буурав.

Өөрийн хөрөнгийн өгөөж

Жич: Тухайн байгууллага нь өөрийн хөрөнгөө хэр үр ашигтай зарцуулж буй тухай мэдээлэл өгдөг. Өөрөөр хэлбэл компани хөрөнгийг хэрхэн ашиг болгож буйг илэрхийлдэг үзүүлэлт юм.

Банкуудын өөрийн хөрөнгийн өгөөж


12.5%

Эх сурвалж: Банкуудын аудитлагдаагүй тайлан

Банкуудын хөрөнгийн өгөөж хадгаламжийн өгөөжөөс давлаа.

Системийн нөлөө бүхий банкуудын өөрийн хөрөнгийн дүн 4.4 их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 21 хувиар өсжээ. Өөрийн хөрөнгөөр буй болгосон ашгийн хэмжээ нэмэгджээ.


Банкуудын өөрийн хөрөнгийн өгөөж, жил бүрийн II улирал



Банкуудын өөрийн хөрөнгийн хүрэлцээ нэмэгджээ.

Банкууд эдийн засгийг дэмжих, гол салбаруудын сэргэлтийг дэмжих хангалттай өөрийн хөрөнгөтэй байна.

Банкуудын өөрийн хөрөнгийн хүрэлцээ, жил бүрийн II улирал



2020	2021	2022
Хаан	ХХБ	Голомт
2020	2021	2022
Төрийн банк	Хас	

Өөрийн хөрөнгийн хүрэлцээ

Жич: Санхүүгийн болон үйл ажиллагааны эрсдэлээс гарах алдагдлыг хаахад хүрэлцэхүйц хэмжээний өөрийн хөрөнгөтэй эсэхийг тодорхойлсон үнэлгээг хэлдэг

Банкуудын өөрийн хөрөнгийн хүрэлцээний дундаж

17%

Хөрвөх чадварын харьцаа

Жич: Богино хугацаат төлбөрүүдийг цаг тухайд
нь төлөх чадварыг хэмждэг харьцаа.


Системийн нөлөө бүхий
банкуудын хөрвөх чадварын
харьцаа үзүүлэлтийн дундаж

36%

Системийн нөлөө бүхий 5 банкны хөрвөх чадварын харьцаа үзүүлэлт өндөр хэвээр байна.

Иргэдэд олгож буй зээлийн хэмжээ өмнөх оны мөн үетэй харьцуулахад өсөлттэй байна. Банкуудын хөрвөх чадварын харьцаа үзүүлэлт өнгөрсөн жилтэй харьцуулахад буурсан хэдий ч хөрвөх чадвар өндөр хэвээр байна.

Банкуудын хөрвөх чадварын харьцаа, жил бүрийн II улирал



2020	2021	2022
Хаан		

2020	2021	2022
ХХБ		

2020	2021	2022
Голомт		

2020	2021	2022
Төрийн банк		

2020	2021	2022
Хас		

Банкуудын зээлийн шимтгэл зээлийн төрлөөс хамааран харилцан адилгүй байна.

Зээлийн шимтгэлийг зээл олгосны дараа харилцагчаас авдаг байна. Хэрэглээний зээлийн дундаж шимтгэл 0.75 хувьтай байна.


Банкны нэр	Хэрэглээний зээл	Орон сууцны зээл	Бизнесийн зээл
Хаан банк	1%	1%	1%
ХХБ	0.5%	0.8%	0.5%
Голомт банк	0.5%	1%	1%
Төрийн банк	1%	1%	1%
Хасбанк	1%	1%	1%
Капитрон банк	0.5%	1%	0.5%
Чингис хаан банк	1%	0.75%	0.5%
Тээвэр хөгжлийн банк	1%	1%	1%
Ариг банк	0.5%	1%	1%
Богд банк	1%	1%	1%
Үндэсний хөрөнгө оруулалтын банк	0.5%	0.5%	0.5%

Дэлхийн ихэнх улсуудад зээлийн шимтгэл 1% байдаг байна.

Харилцагчийн кредит скорингоос хамааран зээлийн шимтгэлийг харилцан адилгүй тогтоодог.

Зээлийн шимтгэл авдаггүй Тажикстан, Узбекистан улсуудын хувьд зээлийн хүүгийн түвшин өндөр байна.

Зээлийн шимтгэлийг тогтоосон хууль, эрх зүйн орчин байхгүй байна.




МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ОРЧИН

2022 оны эхний хагас жил: Эдийн засгийн өсөлт 1.9 хувьтай гарлаа. Тээвэр ложистикийн гацалт, удаашралтай холбоотой уул уурхай, барилга болон тээврийн салбарын өсөлт удаан байгаа нь эдийн засгийн өсөлтөд сөргөөр нөлөөлжээ. Харин үйлчилгээ, худалдааны салбарын сэргэлт харьцангуй хурдан байсан нь эдийн засгийн өсөлтөд эерэг нөлөө үзүүлжээ. Цар тахлын эсрэг баримталж буй бодлогыг сулруулсан нь дотоод эрэлтийг нэмэгдүүлж хэрэглээ, экспортыг нэмэгдүүлэх нөхцөлийг бүрдүүлжээ.

Төлөв байдал: Хэрэв цаашид хил, гаалийн нөхцөл байдал хүндрэлтэй, Орос-Украины нөхцөл байдал удаан үргэлжилбэл манай улсын хувьд эдийн засгийн өсөлт ирэх улирлуудад агших эрсдэл өндөр байна. Нийлүүлэлтээс үүдэлтэй инфляцын түвшин өндөр байгаа нь цаашид хадгалагдах төлөвтэй байна.

2022 оны эхний хагас жилд эдийн засаг 1.9 хувиар өсөв.

Тээвэр ложистикийн хязгаарлалтын улмаас уул уурхайн салбар удааширсан, барилгын салбарын өсөлт саарсан нь эдийн засгийн сэргэлтэд сөргөөр нөлөөлсөн хэдий ч үйлчилгээ, тэр дундаа жижиглэн худалдаа, мэдээлэл холбооны салбарын өсөлт нь эдийн засаг аажмаар сэргэхэд чухал нөлөө үзүүллээ. Цар тахлын эсрэг бодлогыг зөөлрүүлсэн нь эдийн засгийн дотоод эрэлтийг нэмэгдүүлж, эдийн засгийн өсөлтөд эергээр нөлөөлж байна.




Гадаад худалдааны тэнцэл өмнөх оны мөн үеэс 64 хувиар өсжээ.

Хил, гаалийн хязгаарлалттай байсан хэдий ч нүүрс болон зэсийн экспортын хэмжээ нэмэгдэж цар тахлын өмнөх үетэй тэнцэж ирсэн нь гадаад худалдааны тэнцэл ашигтай гарахад нөлөөллөө.


Импортын бараа бүтээгдэхүүний бодит хэмжээ өсөлтгүй байгаа хэдий ч гадаад зах зээл дээрх үнийн өсөлтөөс шалтгаалан импортын хэмжээ цаашид ч нэмэгдэх төлөвтэй байна.

Хил, гаалийн хязгаарлалт нь экспортын өсөлтөд сөргөөр нөлөөж буй хэдий ч цаашид нэмэгдэх төлөвтэй байна.

Хувиар




Импорт тогтвортой байна.



Экспортын нөхцөл байдал сайжирч худалдааны тэнцэл ашигтай гарлаа.

Тэрбум.доллар




Төгрөгийн нэрлэсэн ханш суларч цаашид төлбөрийн тэнцэл ашигтай гарах хүлээлтийг бий болгож байна.


Төгрөгийн бодит ханш суларч манай улсын бараа бүтээгдэхүүн бусад улстай харьцуулахад хямдарч байна.

Төлбөрийн тэнцэл 104 сая ам.долларын алдагдалтай гарчээ. Экспортын үйл ажиллагаа эрчимжсэн нь төлбөрийн тэнцлийн алдагдлыг буурахад чухал нөлөө үзүүлээ.

Төгрөгийн нэрлэсэн болон бодит үйлчилж буй ханш




Төлбөрийн тэнцэл




Эдийн засагт тодорхой бус байдал нэмэгдэх нь иргэдийн валют худалдаж авах сэдлийг нэмэгдүүлж байна.

Хүнс болон тээврийн үнийн өсөлт нь өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний үнийн өсөлтөд нөлөөлж байна.
Импортын барааны үнийн өсөлт нь валютын нөөцөд дарамт болж байна.

5 сарын импорттой тэнцэх валютын нөөц байна.



Импортын бараа бүтээгдэхүүний үнийн тогтвортой бус байдал нь инфляцад хүчтэй нөлөөлж байна




Өрхийн зарлага нь орлогоосоо 15.3 мянган төгрөгөөр давжээ.


Төрөөс олгож буй хөнгөлөлтүүд буурсан нь өрхийн орлого буурахад нөлөөлжээ.

Өрхийн зарлагын дийлэнх хувийг хүнсний бус бараа бүтээгдэхүүний бодит зарлагын өсөлт эзэлж байна.

Өрхийн бодит орлого 2.2 мянган төгрөгөөр
буурчээ..



Өрхийн бодит зарлага 62.9 төгрөгөөр нэмэгджээ.




Төсвийн тэнцэл өмнөх онтой харьцуулахад ашигтай байна.


Төрөөс олгож буй эрчим хүч, шатахууны татаасны өсөлт нь нийт төсвийн зарлагын дийлэнх хувийг бүрдүүлж байна. Үндсэн тэнцэл ашигтай гарч төсвийн алдагдлын дарамт буурах төлөвтэй байна.

Төсвийн орлого бүрдүүлэлт хэвийн байна.

ДНБ-д эзлэх хувиар



Нийт төсвийн зарлага буурах төлөвтэй байна.



Төсвийн тэнцэл ашигтай байна

